



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.01 № 1/22 ЧАТ-САТ/2014/09/СТА-ТТЗ

Зөрчил арилгуулах тухай

НДЕГ-ын 2013 оны үйл ажиллагааны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ Үүнд:

1. НДЕГ-ын харилцах данс жилийн эцэст 3,892.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй, Нийгмийн даатгалын санд буцаан төвлөрүүлээгүй байна. Харилцах дансны үлдэгдлийн 96 хувь нь НДЕГ-ын аппарат, НДЕГ-ын төв төрийн сан, НДЕГ-ын маягтын орлого зарлагын харилцах дансдуудад төвлөрч, үлдэгдэл 4 хувь нь Аймгуудын нийгмийн даатгалын хэлтсүүдэд байршиж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх дуусах бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.
2. Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хууль, түүнд нийцүүлэн НДҮЗ-ийн тогтоосон төсвийн хуваариар: Нийгмийн даатгалын сангаас санхүүжигдэх батлагдсан төсөв 23,676.9 сая төгрөг, түүний гүйцэтгэл нь 23,759.8 сая төгрөг болж 82.9 сая төгрөгөөр илүү санхүүжигдсэн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 3.1.1 дэх хэсгийн заалтыг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл болох НДЕГ-ын аппаратын харилцах дансны үлдэгдэл 632.8 сая төгрөг, НДЕГ төв төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 1,580.8 сая төгрөг, Маягтын харилцах дансны 587.3 сая төгрөг, нийт 2,800.9 сая төгрөг, мөн нийгмийн даатгалын сангаас илүү санхүүжигдсэн 82.9 сая төгрөг, нийт дүнгээр 2,883.8 сая төгрөгийг Улсын Нийгмийн Даатгалын Санд буцаан төвлөрүүлэх
2. Цаашид жил бүр төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг Төсвийн тухай хуулийн дагуу Нийгмийн даатгалын санд буцаан төвлөрүүлж байх

Дээрх зөрчлүүдийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2014 оны 6 дугаар сарын 1-ний дотор гаргаж, Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Ц.Уртнасан, Санхүү төлөвлөлтийн хэлтсийн дарга Ч.Чулуунчимэг нарт даалгав.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
АУДИТОР

Л.МӨНХЦАЦРАЛ



УХА0122